

# УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс нуур-Тэсийн голын сав газрын захиргааны 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/46/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаангом хот 2023 он	Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Аудитор: Б.Одгэрэл Утас: 86032989, Цахим хаяг: Odgerelb@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан.....
  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
5. Аудитын илрүүлэлт .....

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шүүд захирагч



УВС НУУР-ТЭСИЙН ГОЛЫН САВ  
ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГА  
М.АНХБАЯР ТАНАА

**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400. Увс аймаг, Улаангом сум,  
Ө.Бадрахын гудамж  
Утас: 70-45-33-17. Факс: (976)70-45-33-17,  
E-mail: uvs@audit.gov.mn

2023.02.08 № УБА-2023/АБ/НА - СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Увс нуур-Тэсийн голын сав газрын захиргааны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Увс нуур-Тэсийн голын сав газрын захиргааны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

2023.02.08

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>19,897,947.79</b>	<b>14,370,604.00</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	00.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	00.00	00.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	00.00	00.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	00.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	00.00	12,604.00
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	00.00	12,604.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>19,897,947.79</b>	<b>14,358,000.00</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>19,897,947.79</b>	<b>14,358,000.00</b>
35410	Бичиг хэргийн материал	6,500,500.00	6,461,300.00
35420	Аж ахуйн материал	1,327,500.00	1,526,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	190,000.00	00.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	11,879,947.79	6,370,700.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>70,301,738.53</b>	<b>45,162,310.37</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>70,301,738.53</b>	<b>45,162,310.37</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>70,301,738.53</b>	<b>45,162,310.37</b>
39203	Авто-тээврийн хэрэгсэл	98,667,073.78	98,667,073.78
39204	Хуримтлагдсан элэгдэл	(43,288,435.26)	(61,061,757.06)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	27,242,491.00	27,242,491.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(13,433,778.44)	(20,005,208.60)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	8,240,687.13	8,240,687.13
39208	Хуримтлагдсан элэгдэл	(7,126,299.68)	(7,920,975.88)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	00.00	00.00
39301	Програм хангамж	250,000.00	250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(250,000.00)	(250,000.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>90,199,686.23</b>	<b>59,532,914.37</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	00.00	00.00
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	00.00	00.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	00.00	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	00.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	00.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	00.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>90,199,686.32</b>	<b>59,532,914.37</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	90,199,686.32	59,532,914.37
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	90,199,686.32	59,532,914.37
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>90,199,686.32</b>	<b>59,532,914.37</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	90,199,686.32	90,199,686.32
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	(30,666,771.95)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>90,199,686.32</b>	<b>59,532,914.37</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>214,325,500.00</b>	<b>169,649,740.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>13,880,000.00</b>	<b>0.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>13,880,000.00</b>	<b>0.00</b>
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	13,880,000.00	0.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>200,445,500.00</b>	<b>169,649,740.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>145,335,700.00</b>	<b>121,714,400.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	145,335,700.00	121,714,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>55,109,800.00</b>	<b>47,935,340.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	2,030,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,930,000.00	6,712,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	43,179,800.00	39,192,840.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>204,821,036.57</b>	<b>200,316,511.95</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>204,821,036.57</b>	<b>200,316,511.95</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>190,368,623.57</b>	<b>200,068,321.66</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>89,775,986.00</b>	<b>95,600,613.00</b>
210101	Үндсэн цалин	64,657,870.00	70,867,628.00
210102	Нэмэгдэл	19,563,560.00	16,210,371.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,554,556.00	5,656,146.00
210104	Урамшуулал	0.00	2,866,468.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>13,073,123.00</b>	<b>11,951,417.71</b>
210201	Тэтгэврийн даатгал	8,188,823.00	8,130,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	913,047.00	956,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,259,460.00	765,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	153,240.00	185,717.71
<del>210205</del>	<del>Эрүүл мэндийн даатгал</del>	<del>1,558,553.00</del>	<del>1,913,100.00</del>
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>600,000.00</b>	<b>536,000.00</b>
210304	Байрны түрээс	600,000.00	536,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>15,957,700.00</b>	<b>25,505,987.79</b>
210401	Бичиг хэрэг	1,228,100.00	1,648,050.00
210402	Тээвэр, шатахуун	10,824,000.00	14,576,490.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,646,700.00	1,409,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,258,900.00	1,051,800.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	6,680,947.79
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>0.00</b>	<b>1,320,000.00</b>
210502	Хоол, хүнс	0.00	1,320,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>12,721,800.00</b>	<b>645,000.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	139,000.00
210604	Урсгал засвар	12,721,800.00	645,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>13,780,000.00</b>	<b>17,314,500.00</b>

210702	Дотоод албан томилолт	13,780,000.00	17,314,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	17,633,678.00	12,149,025.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,930,000.00	11,413,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	124,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	52,500.00	146,025.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	112,178.00	208,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	36,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	215,000.00	220,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	26,826,336.57	35,045,778.16
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	250,000.00	9,906,350.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	26,576,336.57	25,139,428.16
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>14,452,413.00</b>	<b>248,190.29</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>14,452,413.00</b>	<b>248,190.29</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	13,196,100.00	
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	1,256,313.00	248,190.29
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,048,513.00	79,140.29
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	207,800.00	169,050.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>9,504,463.43</b>	<b>(30,666,771.95)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>9,504,463.43</b>	<b>(30,666,771.95)</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>200,445,500.00</b>	<b>169,649,740.00</b>
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>200,445,500.00</b>	<b>169,649,740.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>145,335,700.00</b>	<b>121,714,400.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>145,335,700.00</b>	<b>121,714,400.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	145,335,700.00	121,714,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>55,109,800.00</b>	<b>47,935,340.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	2,030,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,930,000.00	6,712,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	43,179,800.00	39,192,840.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>192,457,100.00</b>	<b>169,649,740.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>192,457,100.00</b>	<b>169,649,740.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>178,004,687.00</b>	<b>169,401,549.71</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>91,305,006.00</b>	<b>95,613,217.00</b>
210101	Үндсэн цалин	64,521,500.00	70,326,021.00
210102	Нэмэгдэл	19,699,900.00	15,804,060.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,083,576.00	6,616,668.00
210104	Урамшуулал	0.00	2,866,468.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>11,544,103.00</b>	<b>11,951,417.71</b>
210201	Тэтгэврийн даатгал	8,188,823.00	8,240,058.73
210202	Тэтгэмжийн даатгал	913,047.00	965,030.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	730,440.00	772,023.30
210204	Ажилгүйдлийн даатгал	153,240.00	170,520.85
210205	Эрүүл мэндийн даатгал	1,558,553.00	1,803,783.95
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>600,000.00</b>	<b>536,000.00</b>
210304	Байрны түрээс	600,000.00	536,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>17,747,200.00</b>	<b>18,316,090.00</b>
210401	Бичиг хэрэг	639,600.00	1,148,100
210402	Тээвэр, шатахуун	11,744,000.00	14,576,490.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,646,700.00	1,409,700.00
210404	Ном, хэвлэл	1,600,000.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,116,900.00	1,181,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>356,400.00</b>	<b>3,138,000.00</b>
210502	Хоол, хүнс	0.00	2,860,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	356,400.00	278,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>12,899,800.00</b>	<b>1,556,200.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	178,000.00	139,000.00
210604	Урсгал засвар	12,721,800.00	645,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>15,873,500.00</b>	<b>17,314,500.00</b>
210702	Дотоод албан томилолт	15,873,500.00	17,314,500.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>26,563,678.00</b>	<b>12,182,325.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,068,678.00	11,446,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	148,500.00	124,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	146,025.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	52,500.00	208,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	36,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	220,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,115,000.00</b>	<b>8,793,800.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,115,000.00	8,793,800.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>14,452,413.00</b>	<b>248,190.29</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	13,196,100.00	0.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>1,256,313.00</b>	<b>248,190.29</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,048,513.00	79,140.29
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг Нэмэлт санхүүжилт	207,800.00	169,050.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>		
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>		
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>		
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>		
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>		
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний өөрчлөлт	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>			7,436,177.57		7,436,177.57
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>			7,436,177.57		7,436,177.57
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн			798,647.42		798,647.42
C08	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>			<b>90,199,686.32</b>		<b>90,199,686.32</b>
D01	<b>2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>			<b>90,199,686.32</b>		<b>90,199,686.32</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>			<b>90,199,686.32</b>		<b>90,199,686.32</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00		-36,679,375.95		-36,679,375.95
D09	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>			<b>59,520,310.37</b>		<b>59,520,310.37</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

ЭЗА	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>121,714,400.00</b>	<b>121,635,259.71</b>	<b>79,140.29</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>121,714,400.00</b>	<b>121,635,259.71</b>	<b>79,140.29</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>121,714,400.00</b>	<b>121,635,259.71</b>	<b>79,140.29</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>95,656,200.00</b>	<b>95,613,217.00</b>	<b>42,983.00</b>
210101	Үндсэн цалин	72,243,600.00	70,326,021.00	1,917,579.00
210102	Нэмэгдэл	16,322,200.00	15,804,060.00	518,140.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,090,400.00	6,616,668.00	473,732.00
210104	Урамшуулал	0.00	2,866,468	-2,866,468.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>11,957,000.00</b>	<b>11,951,417.71</b>	<b>5,582.29</b>
210201	Тэтгэврийн даатгал	8,130,800.00	8,240,058.73	-109,258.73
210202	Тэтгэмжийн даатгал	956,600.00	965,030.88	-8,430.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	765,200.00	772,520.85	20,779.15
210204	Ажилгүйдлийн даатгал	191,300.00	170,520.85	20,779.15
210205	Эрүүл мэндийн даатгал	1,913,100.00	1,803,783.95	109,316.05
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>542,000.00</b>	<b>536,000.00</b>	<b>6,000.00</b>
210304	Байрны түрээс	542,000.00	536,000.00	6,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,821,200.00</b>	<b>4,818,800.00</b>	<b>2,400.00</b>
210401	Бичиг хэрэг	163,300.00	163,300.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	2,587,200.00	2,585,000.00	2,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,018,700.00	1,018,700.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,052,000.00	1,051,800.00	200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>278,600.00</b>	<b>278,000.00</b>	<b>600.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	278,600.00	278,000.00	1,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,477,400.00</b>	<b>1,476,200.00</b>	<b>1,200.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	772,500.00	772,200.00	300.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	139,300.00	139,000.00	300.00
210604	Урсгал засвар	565,600.00	565,000.00	600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,105,000.00</b>	<b>1,105,000.00</b>	<b>0.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,105,000.00	1,105,000.00	0.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,969,200.00</b>	<b>4,948,825.00</b>	<b>20,375.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,383,200.00	4,383,200.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	124,800.00	124,800.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	166,400.00	146,025.00	20,375.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	47,800.00	47,800.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	36,900.00	36,900.00	0.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	210,100.00	210,100.00	0.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>907,800.00</b>	<b>907,800.00</b>	<b>0.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	907,800.00	907,800.00	0.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>121,714,400.00</b>	<b>121,714,400.00</b>	<b>0.00</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>121,714,400.00</b>	<b>121,714,400.00</b>	<b>0.00</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	121,714,400.00	121,714,400.00	0.00
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>	
610001	Төсвийн байгууллага	1	1	
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>8</b>	<b>8</b>	
620001	Удирдах ажилтан	1	1	
620002	Гүйцэтгэх ажилтан	5	5	
620003	Үйлчлэх ажилтан	1	1	
620004	Гэрээт ажилтан	1	1	

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

ЭЗА	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Тайлант оны	
			Гүйцэтгэл	Зөрүү
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>47,766,290.00</b>	<b>-47,766,290.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>47,477,290.00</b>	<b>-47,477,290.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>47,477,290.00</b>	<b>-47,477,290.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		<b>13,497,290.00</b>	<b>-13,497,290.00</b>
210401	Бичиг хэрэг		984,800.00	-984,800.00
210402	Тээвэр, шатахуун		11,991,490.00	-11,991,490.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		391,000.00	-391,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		130,000.00	-130,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>		<b>2,860,000.00</b>	<b>-2,860,000.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		00.00	00.00
210502	Хоол, хүнс		2,860,000.00	-2,860,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		00.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		<b>80,000.00</b>	<b>-80,000.00</b>
210604	Урсгал засвар		80,000.00	-80,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>		<b>16,209,500.00</b>	<b>-16,209,500.00</b>
210702	Дотоод албан томилолт		16,209,500.00	-16,209,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>7,233,500.00</b>	<b>-7,233,500.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		7,063,300.00	-7,063,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		160,300.00	-160,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		9,900.00	-9,900.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		<b>7,886,000.00</b>	<b>-7,886,000.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		7,886,000.00	-7,886,000.00

II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		47,935,340.00	-47,935,340.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		00.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,030,000.00	-2,030,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		6,712,500.00	-6,712,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		39,192,840.00	-39,192,840.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Увс нуур-Тэсийн голын сав газрын захиргаа нь тус сав газрын хэмжээнд усны нөөцийг хомстой, бохирдохоос хамгаалах, боломжит нөөцийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, орон нутгийн болон салбар дундын зохицуулалтыг хангах, усны нөөцийн нэгдсэн менежмент төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлдэг байгууллага юм.

Сав газрын байгалийн унаган төрхийг хадгалах замаар экосистемийн тэнцвэрт байдлыг тэтгэх, хүн ардын сайн сайхан амьдрах нөхцөлийг бүрдүүлж, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжихэд усны нөөцийг нутгийн иргэдийн оролцоонд түшиглэн зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх асуудлыг нэгдмэл байдлаар хангахад оршино” гэсэн эрхэм зорилгын дор 12 зорилт 37 арга хэмжээ дэвшүүлж ажилласан байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Төсвийн тухай хууль, Усны тухай хууль, Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон бусад дагалдах хууль тогтоомж дүрэм журмыг мөрдлөг болгож ажилладаг.

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль -2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ний өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр
- ✓ Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан " Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"
- ✓ Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
- ✓ Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт
- ✓ Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал "Албан томилолтын зардлын тариф" тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс нуур-Тэсийн голын сав газрын захиргааны 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс нуур-Тэсийн голын сав газрын захиргааны 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж болон, нягтлан бодох бүртгэлийн стандарт бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 30,679.4 мянган төгрөгөөр буюу 34 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	0.0	0.0
Бараа материал	19,897.9	14,358.0	5,539.9
Үндсэн хөрөнгө	70,301.7	45,162.3	25,139.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>90,199.7</b>	<b>59,520.3</b>	<b>30,679.4</b>
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	90,199.7	59,520.3	30,679.4
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>90,199.7</b>	<b>59,520.3</b>	<b>30,679.4</b>

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 14,358.0 мянган төгрөг болж 5,539.9 мянган төгрөгөөр буурсан нь бусад хангамжийн материалын зарцуулалтаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгийн данс нь 45,162.3 мянган төгрөг болж 25,139.4 мянган төгрөгөөр буурсан нь хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 59,520.3 мянган төгрөг болж 30,679.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурсантай холбоотой байна.

Тайлант онд авлага, өр төлбөр үүсээгүй байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 234,610.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 234,610.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 109,341.1 мянган төгрөгөөр бууруулж 125,269.3 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулиас шалтгаалсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг тодотголоор 3,554.9 мянган төгрөгөөр бууруулж, төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 127,714.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 121,714.4 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 121,635.3 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь үйл ажиллагааны зардлын төсвийг 79.1 мянган төгрөг дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/					
Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71404-Усны нөөц, нуур, гол мөрний менежмент	121,714.4	121,635.3	79.1	99.9%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Увс нуур-Тэсийн голын сав газрын захиргааны нэмэлт санхүүжилтийн дансанд Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгийн санхүүжилт 2,030.0 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 6,712.0 мянга, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогоос 39,092.8 мянга, нийт 47,835.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, 47,766.3 мянган төгрөгийг зарцуулж, 169.1 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

#### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс нуур-Тэсийн голын сав газрын захиргааны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Одгэрэл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс нуур-Тэсийн голын сав газрын захиргааны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 1.6 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 200.3 сая төгрөгийн 1.0 хувь буюу 2.0 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 1.6 сая төгрөгөөр тогтоолоо.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллагад хамаарах зүйл заалтын хүрээнд биет горим сорилыг хэрэгжүүлсэн. /АБ-4/

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа 148, хугацаа хоцроосон 1 мэдээллийг байршуулсан, хугацаа болоогүй 2 мэдээлэл хүлээгдэж байна.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Увс нуур-Тэсийн голын сав газрын захиргааны 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмж байхгүй.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарч үзэх чухал асуудал байхгүй гэж үзлээ.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

АУДИТЫН ТАЙЛАН



2023 оны 02 сарын 10-ны өдөр